

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2022 /27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Орхон аймаг
2022 он

Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 7035 9826
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 7035 8505
Цахим хаяг: orkhon@audit.gov.mn
Аудитор: Л.Баасандорж
Утас: 99055703
Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр).....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	20
3.8 Аудитын гол асуудал	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
4. Аудитын илрүүлэлт	22
4.1 Залруулсан алдаа	22
4.2 Төлбөрийн акт	22
4.3 Албан шаардлага	22
4.4 Зөвлөмж.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗГНХ	Засгийн Газрын Нөөц Хөрөнгө
ЗДНХ	Засаг Даргын Нөөц Хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УЦУОШТ	Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол, Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ЦУОШГ	Цаг Уур Орчны Шинжилгээний Газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № *11*
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН УС ЦАГ УУР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА
С.ОТГОНБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Орхон аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн биет тооллого хийхэд нийт 16,222.1 мянган төгрөгийн 34 ширхэг бараа материал 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тооллогын бүртгэлийн үлдэгдлээс дутуу, бодитоор байхгүй байхад бүртгэлд үлдэгдлээр тусгасан, шатахууныг зуны улиралд нормоос 15.5 л, өвлийн улиралд нормоос 5.0 л илүү зарцуулж, нийт дүнгээр 461.3 мянган төгрөгөөр нормоос хэтрүүлэн зарцуулсан, үйлчлүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ бүрэн байгуулаагүй, гэрээ дүгнэгдээгүй, орлогын дүн тодорхой бус, “Эрдмин” ХХК-аас хүлээн авах 696.5 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний орлого нь төсөвт төвлөрүүлэгдээгүй бөгөөд “Грийн химистри” ХХК-д 219.0

мянган төгрөг, хувь хүнд 477.5 мянган төгрөг шилжүүлэгдсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал “Журам шинэчлэн батлах тухай”-ын хавсралт “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал “Жишиг норм батлах тухай”-ын хавсралт 1 “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, хавсралт 2 “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-д нийцэхгүй, аудитын оршин байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан (төгрөгөөр)

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,715,217.22	35,613,684.54
33	АВЛАГА	-	23,522.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	23,522.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,715,217.22	35,590,162.54
351	Түүхий эд материал	27,945,919.04	27,457,322.54
35110	Тусгай зориулалттай материал	27,945,919.04	27,457,322.54
354	Хангамжийн материал	8,769,298.18	8,132,840.00
35410	Бичиг хэргийн материал	141,480.00	29,600.00
35420	Аж ахуйн материал	265,000.00	108,950.00
35470	Бусад хангамжийн материал	8,362,818.18	7,994,290.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	594,782,524.22	597,627,065.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	594,782,524.22	597,627,065.99
392	Биет хөрөнгө	175,275,524.22	177,977,065.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	122,366,361.06	122,366,361.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,887,029.92)	(45,820,281.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,955,573.78	70,955,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,502,940.80)	(31,880,869.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,717,862.17	122,963,949.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(177,024,775.08)	(65,191,886.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,635,437.00	8,975,990.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,984,963.99)	(4,391,770.59)
393	Биет бус хөрөнгө	419,507,000.00	419,650,000.00
39301	Программ хангамж	660,000.00	935,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(418,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	419,265,000.00	419,265,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	631,497,741.44	633,240,750.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	72,179.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	72,179.00
413	Өглөг	-	72,179.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	72,179.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	631,497,741.44	633,168,571.53
51	Засгийн газрын хувь оролцоо	631,497,741.44	633,168,571.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	580,682,132.09	580,682,132.09
51101	Өмч: - төрийн	580,682,132.09	580,682,132.09
512	Хуримтлагдсан үр дүн	21,873,985.13	24,306,976.22
51210	Өмнөх үеийн үр дүн	21,873,985.13	10,838,613.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	13,468,363.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,941,624.22	28,179,463.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	631,497,741.44	633,240,750.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	429,996,812.35	401,994,289.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,340,584.17	57,634,089.59
120	Нийтлэг татварын бус орлого	79,340,584.17	57,634,089.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,340,584.17	57,634,089.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	472,200.00	2,358,738.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	58,549,377.67	49,513,684.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	20,319,006.50	5,761,667.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	350,656,228.18	344,360,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	334,314,600.00	330,978,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	334,314,600.00	330,978,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,341,628.18	13,382,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	324,800.00	1,239,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,341,628.18	12,143,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	384,698,969.97	388,525,926.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,698,969.97	388,525,926.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,559,096.16	385,174,730.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,150,974.00	275,925,471.00
210101	Үндсэн цалин	196,342,874.00	197,208,640.00
210102	Нэмэгдэл	71,918,300.00	70,833,803.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,889,800.00	7,883,028.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,925,452.19	36,434,843.00
210201	Тэтгэврийн даатгал	26,001,890.83	25,810,448.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,761,600.00	2,761,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,209,300.00	2,209,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	537,470.75	477,142.99
210205	Эрүүл мэндийн даатгал	5,415,190.61	5,176,351.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,839,700.00	8,327,493.00
210301	Гэрэл, цахилгаан	4,732,100.00	4,222,600.00
210302	Түлш, халаалт	2,735,300.00	2,732,493.00
210303	Цэвэр, бохир ус	1,372,300.00	1,372,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,137,758.00	8,901,223.00
210401	Бичиг хэрэг	1,282,608.00	1,123,073.00
210402	Тээвэр, шатахуун	5,402,170.00	3,971,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,309,500.00	2,352,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	292,400.00	310,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	659,900.00	765,450.00
210408	Бараа материал акталсны зардал	191,180.00	378,600.00
2105	Нормативт зардал	922,500.00	3,767,647.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,452,547.00
210502	Хоол, хүнс	922,500.00	918,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	397,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,043,472.00	8,353,264.18
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,307,972.00	5,640,586.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	269,150.00
210604	Урсгал засвар	2,735,500.00	2,443,528.18
2107	Томилолт, зочны зардал	1,326,000.00	624,000.00
210702	Дотоод албан томилолт	1,326,000.00	624,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,312,500.00	7,699,180.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,453,100.00	4,333,995.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	229,000.00	65,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,100.00	109,545.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	2,283,300.00	2,283,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,900,739.97	35,141,609.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,850,739.97	34,871,609.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,139,873.81	3,351,196.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	639,873.81	2,501,196.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	639,873.81	2,501,196.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,297,842.38	13,468,363.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	45,297,842.38	13,468,363.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	351,250,282.18	346,718,938.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	472,200.00	2,358,738.00
120	Нийтлэг татварын бус орлого	472,200.00	2,358,738.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	472,200.00	2,358,738.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	472,200.00	2,358,738.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	350,778,082.18	344,360,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	334,314,600.00	330,978,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	334,314,600.00	330,978,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,341,628.18	13,382,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	324,800.00	1,239,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,341,628.18	12,143,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	121,854.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	121,854.00	0.00
602	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	351,250,282.18	346,718,938.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,250,282.18	346,718,938.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,988,554.37	343,367,742.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,150,974.00	275,876,814.00
210101	Үндсэн цалин	196,342,874.00	197,159,983.00
210102	Нэмэгдэл	71,918,300.00	70,833,803.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,889,800.00	7,883,028.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,925,452.19	36,434,843.00
210201	Тэтгэврийн даатгал	26,001,890.83	25,810,448.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,761,600.00	2,761,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,209,300.00	2,209,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	537,470.75	477,142.99
210205	Эрүүл мэндийн даатгал	5,415,190.61	5,176,351.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,839,700.00	8,327,493.00
210301	Гэрэл, цахилгаан	4,732,100.00	4,222,600.00
210302	Түлш, халаалт	2,735,300.00	2,732,493.00
210303	Цэвэр, бохир ус	1,372,300.00	1,372,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,751,700.00	7,954,210.00
210401	Бичиг хэрэг	999,800.00	734,710.00
210402	Тээвэр, шатахуун	5,355,100.00	3,947,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,309,500.00	2,352,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	292,400.00	310,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	794,900.00	609,400.00
2105	Нормативт зардал	1,430,500.00	3,719,747.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	2,452,547.00
210502	Хоол, хүнс	922,500.00	918,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	508,000.00	349,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,201,728.18	2,967,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,694,800.00	783,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	142,600.00	329,150.00
210604	Урсгал засвар	7,364,328.18	1,854,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,326,000.00	624,000.00
210702	Дотоод албан томилолт	1,326,000.00	624,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,312,500.00	7,193,085.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,453,100.00	3,827,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	229,000.00	65,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,100.00	109,545.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	2,283,300.00	2,283,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000.00	270,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,261,727.81	3,351,196.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	621,854.00	850,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	121,854.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	850,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	639,873.81	2,501,196.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	639,873.81	2,501,196.00
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,682,132.09	28,984,893.22	-23,224,031.18	586,442,994.13
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(199,826.07)	(199,826.07)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,682,132.09	28,984,893.22	-23,423,857.25	586,243,168.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(43,269.00)	-	(43,269.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	45,297,842.38	45,297,842.38
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,682,132.09	28,941,624.22	21,873,985.13	631,497,741.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,035,372.10)	(11,035,372.10)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,682,132.09	28,941,624.22	10,838,613.03	620,462,369.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(762,161.00)	-	(762,161.00)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	13,468,363.19	13,468,363.19
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	580,682,132.09	28,179,463.22	24,306,976.22	633,168,571.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %-аар
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	331,978,000.00	330,845,542.00	1,132,458.00	99.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,978,000.00	330,845,542.00	1,132,458.00	99.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,978,000.00	330,845,542.00	1,132,458.00	99.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,049,920.00	275,876,814.00	173,106.00	99.9%
210101	Үндсэн цалин	197,240,320.00	197,159,983.00	80,337.00	100.0%
210102	Нэмэгдэл	70,919,800.00	70,833,803.00	85,997.00	99.9%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,889,800.00	7,883,028.00	6,772.00	99.9%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,394,080.00	36,434,843.00	959,237.00	97.4%
210201	Тэтгэврийн даатгал	26,347,680.00	25,810,448.05	537,231.95	98.0%
210202	Тэтгэмжийн даатгал	2,761,600.00	2,761,600.00	-	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,209,300.00	2,209,300.00	-	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	552,300.00	477,142.99	75,157.01	86.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,523,200.00	5,176,351.96	346,848.04	93.7%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,633,600.00	7,633,600.00	-	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	4,222,600.00	4,222,600.00	-	100.0%
210302	Түлш, халаалт	2,258,600.00	2,258,600.00	-	100.0%
210303	Цэвэр, бохир ус	1,152,400.00	1,152,400.00	-	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	4,169,800.00	4,169,800.00	-	100.0%
210401	Бичиг хэрэг	470,000.00	470,000.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	2,308,100.00	2,308,100.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	752,100.00	752,100.00	-	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	118,700.00	118,700.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	520,900.00	520,900.00	-	100.0%
2105	Нормативт зардал	349,200.00	349,200.00	-	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	349,200.00	349,200.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	620,300.00	620,300.00	-	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	506,200.00	506,200.00	-	100.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	114,100.00	114,100.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,761,100.00	5,760,985.00	115.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,590,100.00	2,590,100.00	-	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	65,400.00	65,340.00	60.00	99.9%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,600.00	109,545.00	55.00	99.9%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	132,000.00	-	100.0%
210807	Газрын төлбөр	2,089,000.00	2,089,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	331,978,000.00	330,845,542.00	1,132,458.00	99.7%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330,978,000.00	328,486,804.00	2,491,196.00	99.2%
131001	Улсын төсвөөс санхүүжих	330,978,000.00	328,486,804.00	2,491,196.00	99.2%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	2,358,738.00	(1,358,738.00)	235.9%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,358,738.00	(1,358,738.00)	235.9%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23.00	23.00	-	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	2021.12.31
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,382,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,382,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,522,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	693,893.00
210302	Түлш, халаалт	473,893.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,784,410.00
210401	Бичиг хэрэг	264,710.00
210402	Тээвэр, шатахуун	1,639,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	192,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,500.00
2105	Нормативт зардал	3,370,547.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,452,547.00
210502	Хоол, хүнс	918,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,347,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	277,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	215,050.00
210604	Урсгал засвар	1,854,700.00
2107	Томилолт, зочны зардал	624,000.00
210702	Дотоод албан томилолт	624,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,432,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,237,800.00
210807	Газрын төлбөр	194,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	850,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,382,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,382,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,239,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,143,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төв (цаашид “УЦУОШТ” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөг, нэмэлт орлого, урсгал зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Баасандорж гүйцэтгэж, хяналтыг гүйцэтгэгч талаас тус компанийн чанарын хяналтын менежер М.Бямбадорж, захирал Б.Байгал нар, захиалагч талаас Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн УЦУОШТ нь “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний чанартай шуурхай мэдээллээр аймаг орон нутгийнхаа хэрэгцээг хангах, байгалийн аюултай болон гамшигт үзэгдэл орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилготойгоор ЦУОШГ-ын үйл ажиллагааны дараах тэргүүлэх чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- ✓ Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- ✓ Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- ✓ Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Нийгмийн даатгалын тухай багц хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэгт 2021 онд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын хувьд хөрөнгийн тооллого үнэн зөв, иж бүрэн хийгдээгүй, байгууллагын хяналтад үл орших хөрөнгүүдийг оршин буй мэтээр тоолсон, өглөг авлагын

тооцоо бүрэн нийлээгүй, үндсэн хөрөнгийн паспортжуулалт, картжуулалт хийгдээгүй, тусгай зориулалтын материал болох борооны пуужинг зориулалтын бус байранд хадгалсан, агуулахын бүртгэл хөтлөгдөөгүй, зохион байгуулалтгүй, нэмэлт орлогыг төлөвлөх, зохион байгуулах, цуглуулах, хянах процесс сул, хөрөнгө болон нягтлан бодох бүртгэлээр тавигдах хяналт сул байна.

2021 онд тус байгууллага нь байгаль орчин, цаг уурын төрөл бүрийн мэдээ, мэдээллийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй хүргэх, үйлчилгээний ил тод байдлыг хангах, улмаар хүний хөгжлийг идэвхжүүлэх зорилгоор олон улсын MNS ISO 9001:2016 (MNS ISO 9001:2016) стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гэрчилгээг 3 жилийн хугацаатай авсан нь байгууллагын ерөнхий үйл ажиллагааны хяналт үр нөлөөтэй байгааг илтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2019 онд байгууллагын даргын А/21 тоот тушаалын дагуу тус байгууллагын дотоод аудитын нэгж нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Тайлант оны 7-р сард санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна. Дотоод хяналт, аудитыг байгууллагын даргын 2019 оны 11 сарын 01-ний А/05 тоот тушаалаар баталсан дотоод хяналтын журмын дагуу хэрэгжүүлж ажилладаг байна. Мөн Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн бөгөөд эрсдэлгүй гэж дүгнэжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 331,978.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,639.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,647.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,743.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Авлага	-	23.5	23.5	100
Урьдчилгаа	-	-	-	-
Бараа материал	36,715.2	35,590.2	(1,125.0)	(3.1)
Үндсэн хөрөнгө	594,782.5	597,627.1	2,844.5	0.5
Нийт хөрөнгө	631,497.7	633,240.7	1,743.0	0.3
Өр төлбөр	-	72.2	72.2	100
Засгийн газрын оролцоо	631,497.7	633,168.5	1,670.8	0.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмч	631,497.7	633,240.7	1,743.0	0.3

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 2 данстай болно.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210013015 тоот дансаар 334,463.8 мянган төгрөгийн орлого орж, зарцуулагдсан байна. Үүний 330,978.0 мянган төгрөг нь санхүүжилтийн орлого, 607.6 мянган төгрөг нь ХЧТАТ-ийн орлого, 2,358.7 мянган төгрөг нь тус байгууллагын төлбөртэй үйлчилгээ болох шинжилгээний орлого, 519.5 мянган төгрөг нь нэр данс зөрүүтэй ажил гүйлгээнээс үүссэн орлого байна. Эдгээр мөнгөн орлогоос 519.5 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээ залруулагдаж, 331,453.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, үлдэгдэл 2,491.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 100210013402 тоот дансаар 13,382.2 мянган төгрөгийн орлого орж зарцуулагдсан байна. Мөнгөн орлого нь цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай холбоотойгоор Эрдэнэт сангаас санхүүжүүлсэн 3,000.0 мянган төгрөгийн орлого, цөлжилтийн судалгааг санхүүжүүлэхэд ЦУОШГ-аас санхүүжүүлсэн 139.2 мянган төгрөгийн орлого, гэр интернэт, сим карт худалдан авахад зориулсан ЦУОШГ-аас санхүүжүүлсэн 1,100.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон төлөвлөгөөнөөс давсан орлого 9,133.0 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 13,372.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 10.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Тайлант онд нийгмийн даатгалын байгууллагад 25.2 мянган төгрөгийг илүү төлж тайлагнаснаас үүдэн авлага үүссэн байна. Тайлант онд 607.6 мянган төгрөгийн ХЧТА-тэй холбоотой авлага нийгмийн даатгалын байгууллагаас үүссэн бөгөөд бүрэн цуглуулагдаж, ажиллагсад олгогдсон байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 3.1%-аар буюу 1,125.0 мянган төгрөгөөр буурсан байна. Уг бууралтад дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын материал тайланд онд өмнөх оноос 488.6 мянган төгрөгөөр буюу 1.7%-аар буурсан нь 1,464.5 мянган төгрөгийн худалдан авалт, 5,207.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан материал зэргээр өсөж, 36.3 мянган төгрөгийн материалыг бичиг хэргийн зардалд, 378.6 мянган төгрөгийн материалыг байгууллагын өмч хамгаалах комиссын шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/15 дугаар тушаалаар акталсан, 231.0 мянган төгрөгийн материалыг эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд, 269.1 мянган төгрөгийн материалыг хөдөлмөр хамгааллын зардалд, 120.7 мянган төгрөгийн материалыг урсгал засварын зардалд, 5,168.5 мянган төгрөгийн материалыг лаборатори болон шинжилгээний багаж техник хэрэгслийн зардалд, 506.1 мянган төгрөгийн материалыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулсан зэрэг нөлөөлсөн байна.
- 2,221.5 мянган төгрөгийн витаминь багц, маск, нэг удаагийн оношлуур болон бээлий, гар ариутгагч, эмийн сан зэргийг Ковид 19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор "Шидэт номин" ХХК-аас худалдан авч, зарцуулсан байна. Үүний нөлөөгөөр эм боох материал үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.
- Бичиг хэргийн материал өмнөх оноос 111.9 мянган төгрөгөөр буюу 79.1%-аар буурсан нь 734.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 240.1 мянган төгрөгийн материалыг ЦУОШГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан зэргээр өсөж, 1,086.7 мянган төгрөгийн материалын бичиг хэргийн зардалд зарцуулсантай холбоотой байна.

- Аж ахуйн материал өмнөх оноос 156.0 мянган төгрөгөөр буюу 58.9%-аар буурсан нь 609.4 мянган төгрөгийн аж ахуйн материал төсвийн хөрөнгөөр худалдан авч, үүнээс 765.4 мянган төгрөгийн материалыг бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлсийн зардалд зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Тайлант онд 1,689.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн, 25.0 мянган төгрөгийн принтерийн сэлбэг хэрэгсэл худалдан авч урсгал засварын зардалд бүгдийг зарцуулснаар уг материалын данс үлдэгдэлгүй илэрхийлэгдсэн байна.
- Тайлант хугацаанд 3,971.3 мянган төгрөгийн шатахуун орлогод авсны 24.0 мянган төгрөгийн шатахуун нь урамшуулалд үнэ төлбөргүй, үлдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийгдэж, бүгд тээвэр, шатахууны зардалд зарцуулагдаж, үлдэгдэлгүй тайлагнагджээ.
- Тайлант онд 918.0 мянган төгрөгийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг лабораторийн ажилчдын хор саармагжуулах зориулалтаар хүнсний материал болгон худалдан авалт хийж, ажиллагсад тавьж олгосноор үлдэгдэлгүй тайлагнагджээ.
- Бусад хангамжийн материал тайлант онд өмнөх оноос 368.5 мянган төгрөгөөр буюу 4.4%-аар буурсан нь ЦУОШГ-аас 290.3 мянган төгрөгийн аврах хантааз, өвлийн хувцас зэргийг үнэ төлбөргүй хүлээн авсан, 369.2 мянган төгрөгийн бусад хөдөлмөр хамгааллын хувцсыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 22.1 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслийг багаж, техник хэрэгслийн зардалд, 397.1 мянган төгрөгийн материалыг нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд, 608.8 мянган төгрөгийн материалыг урсгал засварын зардалд зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 0.5%-аар буюу 2,844.5 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд дараах хөрөнгүүдийн хөдөлгөөн, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

- Барилга байгууламжид тайлант онд хөдөлгөөн гараагүй, харин тайлант оны 15,135.7 мянган төгрөгийн элэгдэл, өмнөх онд үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцоолж дутуу тооцоолсон элэгдлийн зардлын нөхөх дүн 11,797.5 мянган төгрөгөөр дансны үнэ буурч, хуримтлагдсан элэгдэл 26,933.2 мянган төгрөгөөр буюу 142.6%-аар өсөж, барилга байгууламжийн дансны үнэ 26%-аар буурсан байна.
- Тээврийн хэрэгсэл дансанд тайлант онд мөн хөдөлгөөн гараагүй бөгөөд 9,377.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотойгоор хуримтлагдсан элэгдэл 41.7%-аар өсөж, дансны үнэ 19.4%-аар буурчээ.
- Тайлант онд машин, тоног төхөөрөмжид ЦУОШГ-аас 3,940.9 мянган төгрөгийн 4 нэр төрлийн мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 508 тоот тогтоол “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох”-ын дагуу 112,931.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, бүрэн элэгдсэн хөрөнгийг данснаас хасаж, 44,586.8 мянган төгрөгөөр буцаан орлогод авсан байна. Мөн ТӨБЗГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 220 тоот тогтоол “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай”-ын дагуу 8,350.0 мянган төгрөгийн ус нэрэгч багаж тоног төхөөрөмжийг акталсан байна. Тайлант онд уг бүлэг хөрөнгөд 9,448.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан бөгөөд эдгээрийн нөлөөгөөр хөрөнгийн түүхэн өртөг 72,753.9 мянган төгрөгөөр буюу 37.2%-аар, хуримтлагдсан элэгдэл 111,832.9 мянган төгрөгөөр буюу 63.2%-аар буурч, дансны үнэ 39,079.0 мянган төгрөгөөр буюу 209.1%-аар өссөн байна.
- Тайлант онд тавилга, эд хогшилд дараах хөдөлгөөн гарсан байна. ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 508 тоот тогтоол “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох”-ын дагуу 2,370.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, бүрэн элэгдсэн хөрөнгийг данснаас хасаж, 711.2 мянган төгрөгөөр буцаан орлогод авсан байна. Уг бүлэг хөрөнгөд тайлант онд 777.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан бөгөөд эдгээрийн нөлөөгөөр хөрөнгийн түүхэн өртөг 1,659.4 мянган төгрөгөөр буюу 15.6%-аар, хуримтлагдсан элэгдэл 1,513.2 мянган төгрөгөөр буюу 26.6%-аар, дансны үнэ 66.2 мянган төгрөгөөр буюу 1.4%-аар тус тус буурсан байна.
- ЦУОШГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/233 тоот тушаал “Санхүүгийн программ хангамж худалдан авах зардал гаргах тухай”-ын дагуу 275.0 мянган төгрөгийн санхүүгийн үйл ажиллагаанд нярвын программ үнэ төлбөргүй хүлээн

авсан ба тайланд онд санхүүгийн программд 132.0 мянган төгрөгийн хасагдуулга тооцсон зэргийн үр нөлөөгөөр программ хангамжийн анхны өртөг 41.7%-аар, хуримтлагдсан хасагдуулга 31.6%-аар, дансны үнэ 59.1%-аар тус тус өссөн байна.

- Тус байгууллага нь ДЦС 3-300, ДЦС 11-1102, Найрамдалын 5-513 гэсэн 3 төрлийн, нийт 419,265.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхтэй бөгөөд уг хөрөнгийн дүнд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх онд 0 үлдэгдэлтэй байсан бол тайланд онд 72.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Тайлант онд цалингийн 227,668.5 мянган төгрөгийн, НДШ-ийн 68,405.4 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 17,002.5 мянган төгрөгийн, албан томилолтын 624.0 мянган төгрөгийн, байгууллагад өгөх 31,197.1 мянган төгрөгийн өр төлбөрүүд үүссэнээс 28.2 мянган төгрөгийн цалингийн өглөг, 44.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөрүүд төлөгдөөгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 1,670.8 мянган төгрөгөөр буюу 0.3%-аар өсөж 633,168.6 мянган төгрөг болжээ. Үүнд, тайлант үеийн үр дүн 13,468.3 мянган төгрөгөөр өсөж, өмнөх үеийн алдааны залруулга 11,797.5 мянган төгрөгөөр өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнг буурсан, үндсэн хөрөнгө данснаас хасалттай холбоотойгоор 762.2 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл хуримтлагдсан үр дүн рүү хэрэгжсэн зэрэг нөлөөлсөн байна. Эдгээрийн нөлөөгөөр хуримтлагдсан үр дүн 2,433.0 мянган төгрөгөөр буюу 11.1%-аар өсөж, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс 2.6%-аар буурсан байна. Төрийн өмчид өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/

Орлогын нэр төрөл	2020	2021	Өөрчлөлт	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	334,314.6	330,978.0	(3,336.6)	(1.0)
Туслах үйл ажиллагааны санхүүжилт	472.2	2,358.7	1,886.5	399.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,868.4	55,275.3	(23,593.1)	(29.9)
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	324.8	1,239.2	914.4	281.5
Эрдэнэт сангаас хуваарилсан хөрөнгө	4,500.0	3,000.0	(1,500.0)	(33.3)
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,516.8	9,143.0	(2,373.8)	(20.6)
Нийт орлого	429,996.8	401,994.2	(28,002.6)	(6.5)

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 28,002.6 мянган төгрөгөөр буюу 6.5%-аар буурсан байна. Үүнд, урсгал үйл ажиллагааны зардлын санхүүжилт 3,336.6 мянган төгрөгөөр буюу 1%-аар, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 23,593.1 мянган төгрөг буюу 29.9%-аар, Эрдэнэт сангаас хуваарилсан хөрөнгө 1,500.0 мянган төгрөг буюу 33.3%-аар, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,373.8 мянган төгрөгөөр буюу 20.6%-аар тус тус буурч, туслах үйл ажиллагааны санхүүжилт 1,886.5 мянган төгрөгөөр буюу 399.5%-аар, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 914.4 мянган төгрөг буюу 281.5%-аар өссөн зэрэг нөлөөлсөн байна. Үүнийг орлогын нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1%-аар буюу 3,336.6 мянган төгрөгөөр буурсан нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын дагуу урсгал санхүүжилт өмнөх оноос буурч батлагдсантай холбоотой байна.
- Өмнөх онд тус байгууллагын туслах үйл ажиллагааны санхүүжилт 200.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл 472.2 мянган төгрөг байсан бол энэ онд төлөвлөгөө 1,000.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэл 2,358.7 мянган төгрөг болж өссөн зэргээс шалтгаалан уг орлого 1,886.5 мянган төгрөгөөр буюу 399.5%-аар өссөн байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого тайлант онд өмнөх оноос 23,593.1 мянган төгрөгөөр буюу 29.9%-аар буурсан дараах нөлөөтэй байна. Үүнд:

Хүснэгт 3. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын үзүүлэлт /мянган төгрөг/

Нийлүүлэгч	Орлогын төрөл	Төрөл	2020	2021	Өөрчлөлт	Хувь
БООАЖЯ	Үндсэн хөрөнгө	Тээврийн хэрэгсэл	56,267.6	0.0	(56,267.60)	-100.0
ЦУОШГ	Үндсэн хөрөнгө	Тоног төхөөрөмж	2,281.8	3,940.7	1,658.90	72.7
УЦУОШТ*	Үндсэн хөрөнгө	Тоног төхөөрөмж	0.0	44,586.8	44,586.80	100.0
УЦУОШТ*	Үндсэн хөрөнгө	Тавилга, эд хогшил	0.0	711.2	711.20	100.0

Орхон аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ЦУОШГ	Биет бус хөрөнгө	Программ хангамж	0.0	275.0	275.00	100.0
ЦУОШГ	Бараа материал	Тусгай зориулалтын материал	19,943.0	5,207.2	(14,735.80)	-73.9
ЦУОШГ	Бараа материал	Бичиг хэргийн материал	298.9	240.1	(58.80)	-19.7
ШТС-ууд	Бараа материал	Шатахуун	47.1	24.0	(23.10)	-49.0
ЦУОШГ	Бараа материал	Бусад хангамжийн материал	30.0	290.3	260.30	867.7
ДҮН			78,868.40	55,275.30	(23,593.10)	-29.9

*Жич: * ТӨБЗГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 508 тоот тогтоол "Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох"-ын дагуу хуучин хөрөнгийг данснаас хасаж, дахин үнэлж орлогод авсан дүн болно.*

- Эрдэнэт сангаас хуваарилсан хөрөнгө өмнөх оноос 1,500.0 мянган төгрөгөөр буюу 33.3%-аар буурсан нь тайлант оны зуны улиралд орон даяар хур бороо элбэг, зуншлага сайн байснаас үүдэн "Орхон бороо 1" экспедиц буюу цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг ЦУОШГ-аас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоосонтой шууд холбоотой.
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө энэ онд 914.4 мянган төгрөгөөр буюу 281.5%-аар өссөн нь ЦУОШГ-ын цөлжилтийн судалгааны зардлын санхүүжилт 324.8 мянган төгрөгөөс 139.2 мянган төгрөг болж буурч, харин ЦУОШГ-ын даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/47 тоот тушаалаар "Агаарын бохирдол, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөг бууруулах нь" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоосонцор хэмжигч багажийн мэдээллийг дамжуулах гэр интернэт, сим карт худалдан авах зардлын санхүүжилтэд 1,100.0 мянган төгрөгийг ЦУОШГ-аас олгосонтой холбоотой байна.
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 2,373.8 мянган төгрөгөөр буюу 20.6%-аар буурсан нь өмнөх онд 11,989.0 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний орлого олж үүнээс 472.2 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулж байсан бол тайланд онд 11,501.7 мянган төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 2,358.7 мянган төгрөгийн зарцуулсантай холбоотой байна. Энэ нь тайлант онд зарим гэрээт ажлууд цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн хийгдээгүйтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/			
	2020	2021	Өөрчлөлт	Хувь
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	384,699.0	388,525.9	3,827.0	1.0
УРСГАЛ ЗАРДАЛ	384,699.0	388,525.9	3,827.0	1.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,559.1	385,174.7	1,615.6	0.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,151.0	275,925.5	(225.5)	-0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,925.5	36,434.8	(490.6)	-1.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,839.7	8,327.5	(512.2)	-5.8
Хангамж, бараа материалын зардал	9,137.8	8,901.2	(236.5)	-2.6
Нормативт зардал	922.5	3,767.6	2,845.1	308.4
Эд хогшил, урсгал засварын зардал	10,043.5	8,353.3	(1,690.2)	-16.8
Томилот, зочны зардал	1,326.0	624.0	(702.0)	-52.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,312.5	7,699.2	1,386.7	22.0
Бараа үйлчилгээний бусад зардал	33,900.7	35,141.6	1,240.9	3.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,139.9	3,351.2	2,211.3	194.0
Бусад урсгал шилжүүлэг	500.0	850.0	350.0	70.0
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	639.9	2,501.2	1,861.3	290.9

Нийт зардал өмнөх оноос 1%-аар буюу 3,827.0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант он үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын өсөлтөд бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлт 0.4%-аар буюу 1,615.6 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 194.0%-аар буюу 2,211.3 мянган төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын өсөлтөд ажилчдын цалин хөлс 0.1%-аар буюу 225.5 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардал 1,3%-аар буюу 490.6 мянган төгрөгөөр, тогтмол зардал 5.8%-аар буюу 512.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,6%-аар буюу 236.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 16.8%-аар буюу 1,690.2 мянган төгрөгөөр, томилот, зочны зардал 52.9%-аар буюу 702.0 мянган төгрөгөөр тус тус буурч, нормативт зардал 308.4%-аар буюу 2,845.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 22%-аар буюу 1,386.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3.7%-аар буюу 1,240.9 мянган төгрөгөөр өссөн зэрэг нөлөөлсөн байна.

- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын өсөлтөд бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 70.0% буюу 350.0 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх урсгал шилжүүлэг өмнөх оноос 290.9%-аар буюу 1,861.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 1,670.8 мянган төгрөгөөр буюу 0.3%-аар өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ ЦУОШГ-аас батлагдаж ирсэн MS-Excel программд тулгуурлан системийн дотоод сүлжээгээр боловсруулж, мэдээлэл дамжуулдаг. Батлагдсан маягт аргачлалын дагуу төсвийн саналыг Төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд боловсруулж байгууллагын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж, төсвийн төслөө ЦУОШГ-ын төсвийн мэргэжилтэнд дотоод сүлжээгээр дамжуулан хүргүүлдэг. ЦУОШГ-т хүргэгдсэн төсвийн төсөл батлагдан системийн хэмжээнд дотоод сүлжээгээр илгээгдэж ирдэг.

Батлагдсан төсвийн зарлага болох 333,397.0 мянган төгрөгийн 333,197.0 мянган төгрөг буюу 99.9%-ийг улсын төсвөөр, 200.0 мянган төгрөг буюу 0.1%-ийг төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталжээ.

Тайлант хугацаанд Орхон аймгийн УЦУОШТ-ийн батлагдсан төсвийн хуваарьт 4 удаа дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

- 2021 оны 1 дүгээр сард УИХ-аар батлагдсан анхны төсвийг 720.0 мянган төгрөгийн аудит баталгаажуулах, зэрэглэл тогтоох үйлчилгээ, 80.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн зардлыг нэмж, уг зардлыг төсөв байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр нэмж тодотгон баталсан байна.
- 2021 оны 5 дугаар сард тогтмол зардлаас 939.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 615.9 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 38.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 155.1 мянган төгрөг, томилолт зочны зардлаас 68.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 380.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 20.7 мянган төгрөг, нийт улсын төсвийн урсгал зардлаас 2,219.0 мянган төгрөгийн зардлын хэмнэлт хийж тодотгосон байна. Энэ нь 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 тоот тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой болно.
- 2021 оны 7 дугаар сард дотоод албан томилолтын зардлаас 200.0 мянган төгрөг, даатгалын үйлчилгээний зардлаас 54.6 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татварын зардлаас 17.5 мянган төгрөгийг гэрэл, цахилгааны зардалд 80.0 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 54.6 мянган төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 91.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 46.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулах хүсэлт гарган төсвийн зохицуулалт хийгдсэн байна.
- 2021 оны 12 дугаар сард дотоод албан томилолтын зардлаас 274.2 мянган төгрөг, даатгалын үйлчилгээний зардлаас 87.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 82.8 мянган төгрөгийг гэрэл, цахилгааны зардалд 240.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 87.2 мянган төгрөг, газрын төлбөрт 117.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулах хүсэлт гарган төсвийн зохицуулалт хийгдсэн байна.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 331,978.0 мянган төгрөг болж тодотгосон төсвийн дүн өмнөх оны төлөвлөгөөнөөс 0.8%-аар буюу 2,536.6 мянган төгрөгөөр буурсан бол 2021 оны анхны батлагдсан төсөв нь 0.4%-аар буюу 1,419.0 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна. Эдгээртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 5 Төсвийн төлөвлөлтийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төсвийн төлөвлөлт			2020/2021 оны зөрүү	Хувь	2021 оны тодотгол зөрүү	Хувь
		2020 оны төсвийн төлөвлөгөө	2021 оны анхны батлагдсан төлөвлөгөө	2021 оны батлагдсан төлөвлөгөө				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,514.6	333,397.0	331,978.0	(2,536.60)	-0.8	(1,419.00)	-0.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,514.6	333,397.0	331,978.0	(2,536.60)	-0.8	(1,419.00)	-0.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,162.2	276,162.2	276,162.2	-	0.0	-	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,281.9	37,281.8	37,281.8	(0.10)	0.0	-	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,839.7	8,198.9	7,633.6	(1,206.10)	-13.6	(565.30)	-6.9
2104	Хангамж, бараа материалын зардал	5,414.9	4,694.2	4,169.8	(1,245.10)	-23.0	(524.40)	-11.2
2105	Нормативт зардал	388.0	388.0	349.2	(38.80)	-10.0	(38.80)	-10.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	775.4	775.4	620.3	(155.10)	-20.0	(155.10)	-20.0
2107	Томилолт, зочны зардал	264.0	542.8	-	(264.00)	-100.0	(542.80)	-100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,338.5	5,250.2	5,761.1	422.60	7.9	510.90	9.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50.0	103.5	-	(50.00)	-100.0	(103.50)	-100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	334,514.6	333,397.0	331,978.0	(2,536.60)	-0.8	(1,419.00)	-0.4
131001	Улсын төсвөөс	334,314.6	333,197.0	330,978.0	(3,336.60)	-1.0	(2,219.00)	-0.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200.0	200.0	1,000.0	800.00	400.0	800.00	400.0

Дээрх төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтөд үзүүлсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг тайлбарлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, Ажил олгогчоос төлөх НДШ: 2021 онд уг зардлыг санхүүжүүлэх төсөв өмнөх оны батлагдсан төлөвлөгөөнөөс өөрчлөгдөөгүй, тайлант онд батлуулсан анхны төлөвлөгөөнөөс мөн өөрчлөгдөөгүй байна.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Өмнөх оноос 13.6%-аар буюу 1,206.1 мянган төгрөгөөр буурсан, харин тайлант онд батлагдсан анхны төсөвт 939.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийн тодотгол, 374.6 мянган төгрөгийн төсвийн нэмэлт зарцуулалтын зохицуулалт хийгдэж 565.3 мянган төгрөгөөр буюу 6.9%-аар төсвийг бууруулсан байна. Тайлант онд цэвэр бохир усны зардалд 1 удаа, гэрэл цахилгааны зардалд 2 удаа төсвийн зохицуулалт хийгдсэн.
- Хангамж, бараа материалын зардал: Өмнөх оноос 23%-аар буюу 1,245.1 мянган төгрөгөөр, анх батлагдсан төсвөөс 11.2%-аар буюу 524.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Уг бүлэг зардалд 615.9 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийн 1 удаагийн тодотгол, 91.5 мянган төгрөгийн шуудан холбоо, интернэтийн зардлын төсвийн нэмэлт зохицуулалт 1 удаа хийгдсэн байна.
- Нормативт зардал: Өмнөх оны батлагдсан төсөв болон анхны батлагдсан төсвөөс 10%-аар буюу 38.8 мянган төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь төсвийн хэмнэлтийн горимд шилжиж төсвийг танаж тодотгосонтой холбоотой.
- Эд хогшил, урсгал засварын зардал: Өмнө оны батлагдсан төсөв болон тайлант оны анхны батлагдсан төсвөөс 20%-аар буюу 155.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хэмнэлтийн горимд шилжихтэй холбоотойгоор багаж, техник хэрэгслийн зардлыг 126.6 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын хэрэглэлийн зардлыг 28.5 мянган төгрөгөөр танаж тодотгосонтой холбоотой байна.
- Томилолт, зочны зардал: Өмнөх оны төсвөөс 100%-аар буюу 264.0 мянган төгрөгөөр бага төсөвлөгдсөн батлагдсан байна. Харин анхны батлагдсан төсвөөс бүрэн танагдсан байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн горимтой холбоотой төсвийн тодотголоор 68.6 мянган төгрөг танагдаж, бусад урсгал үйл ажиллагааны зардал 2 удаагийн төсвийн зохицуулалтаар 474.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулахаар төлөвлөсөнтэй холбоотой байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж: Өмнөх оноос 422.6 мянган төгрөгөөр буюу 7.9%-аар, анх батлагдсан төсвөөс 510.9 мянган төгрөгөөр буюу 9.7%-аар тус тус өсөж төсөвлөгдсөн байна. Өмнөх оноос өссөн нь аудитын

үйлчилгээний төлбөрийг тайлант онд нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна. Харин тайлант онд уг бүлэг зардалд төсвийн хэмнэлтээр 380.0 мянган төгрөгийг хасаж тодотгосон байна. Үүнд, бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 22.2 мянган төгрөгөөр, даатгалын үйлчилгээний зардлыг 21.8 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 33.0 мянган төгрөгөөр, газрын төлбөрийг 303.0 мянган төгрөгөөр тус тус хассан байна. Харин төсвийн 2 удаагийн зохицуулалтаар бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 133.2 мянган төгрөгөөр өгсөх, 141.8 мянган төгрөгийн даатгалын үйлчилгээний зардлыг бууруулах, тээврийн хэрэгслийн татварын зардлыг 17.5 мянган төгрөгөөр бууруулах, газрын төлбөрийг 117.0 мянган төгрөгөөр өсгөх зохицуулалтууд хийгдсэн байна.

- **Бараа үйлчилгээний бусад зардал:** Өмнөх оны батлагдсан төсөв болон энэ оны анхны батлагдсан төсвийг 100% хэмнэсэн төсвийн төлөвлөлтийн өөрчлөлт хийгдсэн байна. Үүнд төсвийн хэмнэлтийн горимоор 20.7 мянган төгрөгийг танаж тодотгосон бол 1 удаагийн төсвийн зохицуулалтаар 82.8 мянган төгрөгийг өөр зардал руу гүйлгэн зарцуулах зохицуулалт хийгдэж батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 331,978.0 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 330,978.0 мянган төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 330,845.5 мянган төгрөг буюу 99.7% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	331,978.0	330,845.5	1,132.5	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,978.0	330,845.5	1,132.5	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,978.0	330,845.5	1,132.5	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,049.9	275,876.8	173.1	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,394.1	36,434.8	959.2	97.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,633.6	7,633.6	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,169.8	4,169.8	-	100.0
2105	Нормативт зардал	349.2	349.2	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	620.3	620.3	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,761.1	5,761.0	0.1	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	331,978.0	330,845.5	1,132.5	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	330,978.0	328,486.8	2,491.2	99.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	2,358.7	(1,358.7)	235.9

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 173.1 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 959.2 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 0.1 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 0.3%-аар хэмнэгджээ. Харин улсын төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 330,845.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс 328,486.8 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 2,491.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн туслах үйл ажиллагааны орлогоос 2,358.7 мянган төгрөгийг олж үйл ажиллагаандаа зарцуулсан буюу орлогын төлөвлөгөөг 235.9%-аар биелүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Эрдэнэт сангаас “Орхон бороо 1” экспедицийн цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд 3,000.0 мянган төгрөг, Шунхлай ШТС-аас төлбөртэй үйлчилгээний орлого 10.0 мянган төгрөг, ЦУОШГ-аас цөлжилтийн судалгааны санхүүжилтэд 139.2 мянган төгрөг, “Агаарын бохирдол, хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөг бууруулах нь” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоосонцор хэмжигч багажийн мэдээллийг дамжуулах гэр интернэт, сим карт худалдан авах зардлын санхүүжилтэд 1,100.0 мянган төгрөг, төлөвлөгөөнөөс давсан төлбөртэй үйлчилгээний орлого 9,133.0 мянган төгрөг, нийт 13,382.2 мянган төгрөгийн нэмэлт орлого төвлөрч, үүнээс тогтмол зардалд 693.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын 3,784.4 мянган төгрөг, нормативт зардалд 3,370.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,347.2 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 624.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 1,432.1 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 270.0 мянган төгрөг, шагнал урамшуулалд 850.0 мянган төгрөг зарцуулж, 10.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилттэй холбоотой асуудал

Тайлант онд тус байгууллага нь 115,302.0 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, ашиглалтын хугацаа дуусаж, бүрэн элэгдсэн үндсэн хөрөнгүүдийг данснаас хасаж, ТӨБЗГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 508 тоот тогтоол “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох”-ын дагуу 45,298.0 мянган төгрөгөөр дахин хэмжиж орлогод авсан байна. Уг үндсэн хөрөнгүүдийн дахин үнэлэгдсэн үнэ цэнэ, цаашид ашиглагдах хугацаа зэрэг нь УСНББОУС17, УСНББОУС21, УСНББОУС26 зэрэгт нийцсэн эсэх нь ойлгомжтой бус, тодорхойгүй байна.

Төлбөртэй үйлчилгээний орлогод тавих хяналттай холбоотой асуудал

Тайлант хугацаанд “Авто тээврийн төв” ТӨҮГ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, “Магес консалтант” ХХК, “Дат консалтинг” ХХК, “Петролиум продакшн” ХХК, “Мандал даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК зэрэг компаниудад төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн нь санхүүгийн бус баримтууд, бусад мэдээллээр нотлогдож байна. Тухайлбал, компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн 7.1.2 дугаарт 626.4 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн тухай, Мандал даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК-д цаг агаарын тодорхойлолт хүргүүлэх тухай 2021 оны 24, 50, 72 тоот байгууллагын даргын албан бичгүүд, Дат консалтинг компанийн эрсдэлийн шинжээч н.Жаргалсайханаас тодруулсан ярилцлага гэх зэргийг дурдаж болно. Гэвч санхүүгийн тайлангийн аудитын явцад бид эдгээр үйлчлүүлэгчтэй хамтран ажилласан тухай гэрээ, гэрээ дүгнэсэн акт, төлбөр цуглуулсан анхан шатны баримт зэрэг аудитын хангалттай, зохистой нотолгоог бүрдүүлж чадаагүй болно. Тиймээс гүйцэтгэлийн аудитаар төлбөртэй үйлчилгээний орлогыг төлөвлөлт, гүйцэтгэлд нарийвчилсан горим, сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзэж байна.

Эдгээр асуудалтай холбоотойгоор бидний дүгнэлт хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын бүртгэл, тайлагнал, дотоод хяналттай холбоотой асуудал

2021 оны 12 дугаар сарын 31-ээр байгууллагын бараа материалын бүртгэлд 40 ширхэг, нийт 19,442.8 мянган төгрөгийн өртөгтэй борооны пуужин тайлагнагдсан боловч аудитын биет тестээр нийт 13 ширхэг борооны пуужин бодитоор оршин байна. Үүнээс 3 ширхэг нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгө байгаа бөгөөд эдгээр хөрөнгө нь хадгалалтын горим, нөхцөл, стандарт хангагдаагүй орчинд оршин байна. Аудитын дүнгээр 14,582.1 мянган төгрөгийн өртөгтэй 30 ширхэг борооны пуужин тухайн байгууллагын хяналтад бодитоор оршин байхгүй байгаа бөгөөд эдгээр нь ЦУОШГ-ын агуулахад байгаа гэх боловч Орхон аймгийн УЦУОШТ-ын хяналтад байгаа нөөц мөн эсэхийг аудитын явцад бид хангалттай, зохистой нотолгоогоор баталж чадаагүй.

Хэрвээ уг хөрөнгө нь байгууллагын хяналтад байгаа нөөц мөн байх аваас энэ нь тус байгууллагын 2-3 жилийн хэрэгцээг хангахуйц нөөц болно. Бидний хийсэн ажиглалт, шалгалтаар 2020 болон 2021 онуудын ийм төрлийн хөрөнгийн зарцуулалт жилд 10-18 ширхэг байна. Иймд энэ төрлийн хөрөнгийн нөөцийг бэлтгэхэд зориулж ойрын 2-3 жилд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байж, арвилан хэмнэлт үүсгэх шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 150, хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтууд нийцсэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаж байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төлөвлөлт ба зохицуулалтын талаарх асуудал

Тайлант хугацаанд тус байгууллагын анхны батлуулсан төсөв нь төсвийн зохицуулалт болон тодотголоор нийт 4 удаа өөрчлөлт орж батлагдсан байна.

Энэ асуудал нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт "Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", Сангийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 134 дүгээр тушаал "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1, 3.2 дахь заалтад бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж дүгнэлээ.

Дээрх нөхцөл байдал болон энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1		1		-		-
Нийт дүн	1		1		-		-

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 8-ны өдрийн 45 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгийн хадгалалт, бүртгэл, хяналттай холбоотой асуудал

Бид аудитаар тус байгууллагын хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, картжуулалт, үндсэн хөрөнгийн паспорт хөтлөлт, хөрөнгөд тавигдах дотоод хяналтыг үр нөлөөгүй гэж тодорхойлсон боловч аудитыг гүйцэтгэх цаг хугацааны хязгаарлалтаас үүдэн уг алдаа, зөрчлийг залруулах боломж байгаагүй тул дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 17,564.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг шинжтэй 17379.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, материаллаг бус 184.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

1. Шатахууны бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Тайлант хугацаанд нийт 3,910.3 мянган төгрөгийн 2,430.3 литр шатахууныг худалдан авч зарцуулсныг санхүүгийн программд холбогдох хэмжих нэгж (литр), нэгжийн өртгөөр хэмжиж бүртгэж, тайлагнаагүй байсныг аудитын явцад залруулж, тайлагнасан болно.

4.2 Төлбөрийн акт

Бидний гүйцэтгэсэн аудитаар горим, сорилоор тус байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналд төлбөрийн акт тогтоох түвшний материаллаг алдаа, зөрчил илэрхийлэгдээгүй болно.

4.3 Албан шаардлага

1. Нэмэлт орлогын бүртгэл, тайлагнал, хяналттай холбоотой асуудал

“Эрдмин” ХХК-аас хүлээн авах 696.5 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний орлогыг төсөвт төвлөрүүлэлгүй “Грийн химистри” ХХК-д 219.0 мянган төгрөг, хувь хүнд 477.5 мянган төгрөгийг шилжүүлж, байгууллагын байгаль орчин шинжилгээний лабораторийн чанарын итгэмжлэлтэй холбоотой зардалд зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал “*Журам шинэчлэн батлах тухай*”-ын хавсралт “*Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам*”-ын 1.4 дэх заалт “*Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналтыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ*” гэсэнтэй нийцэхгүй, аудитын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн биет тооллого хийхэд тус байгууллагад бүртгэлтэй 30 ширхэг, нэг бүр нь 486.1 мянган төгрөгийн, нийт 14,582.1 мянган төгрөгийн өртөгтэй борооны пуужин, нэг бүр нь 420.0 мянган төгрөгийн, нийт 840.0 мянган төгрөгийн өртөгтэй 12 м-ийн бетон шон 2 ширхэг, нэг бүр нь 400.0 мянган төгрөгийн, нийт 800.0 мянган төгрөгийн өртөгтэй төмөр хийцийн 2 шон зэрэг нийт 16,222.1 мянган төгрөгийн 34 ширхэг бараа материалууд 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх тооллогын бүртгэлийн үлдэгдлээс дутуу байхад бараа материал үлдэгдэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх заалт “*үнэн зөв байх*”, 13.1 дэх заалт “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дэх заалт “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20.1.4 дэх заалт “*хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажгаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх*” гэсэнтэй нийцэхгүй, аудитын оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Тайлант хугацаанд 2,430.3 литр шатахууныг 3,971.3 мянган төгрөгөөр худалдан авч 9,610 км замыг туулахад зарцуулсан бөгөөд зуны улиралд нормоос 15.5л, өвлийн улиралд нормоос 5.0л илүү зарцуулж, нийт дүнгээр 461.3 мянган төгрөгийн шатахууныг нормоос хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал “*Жишиг норм батлах тухай*”-ын хавсралт 1 “*Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм*”, хавсралт 2 “*Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд*”-д нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөд биет тооллого түүвэрлэн хийхэд санхүүгийн программ дах хөрөнгийн код, тухайн эд хариуцагчийн бүртгэл, нярвын тайлан дахь кодууд зөрүүтэй илэрхийлэгдсэн, үндсэн хөрөнгүүд паспортжуулагдаагүй, эд хариуцагчид хөрөнгө эзэмшүүлсэн карт дахь хөрөнгийн бүртгэл болон нярвын тайлан дахь хөрөнгийн бүртгэл хоорондоо зөрүүтэй тайлагнагдсан, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой анхан шатны баримт, маягтууд хөтлөгдөөгүй, хөрөнгөд тавигдах дотоод хяналт сул байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 19.1,20.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаал “*Маягт заавар батлах тухай*”-ын НХМаягт ҮХ-1, НХМаягт ҮХ-2, НХМаягт ҮХ-3, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаал “*Маягт аргачлал батлах тухай*”-ын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл ҮХ-1 зэрэг анхан шатны баримт, маягтыг хөтлөх

2. Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материал (хүнсний материал)-ыг байнгын системээр бүртгээгүй, нярвын тайлангаар илэрхийлэгдэж буй хөрөнгийн орлого, зарлагын хөдөлгөөн нь ерөнхий журналд огнооны хувьд зөрүүтэй бүртгэгдсэн, эм боох материал, сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материалуудыг тусгай зориулалтын материалын тайланд тусгасан, зарим төрлийн бараа материалаарх хөрөнгийн орлого, зарлага нь нярвын тайланд эсвэл ерөнхий журналд тусгагдаагүй, 6-р сард бичиг хэргийн материалыг бөөн дүнгээр бүртгэлд тусгасан, материалын зарцуулалтад зарлагын баримт хөтлөөгүй, агуулахын бүртгэл хөтөлдөггүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 19.1,20.1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан НХМаягт БМ-3, НХМаягт БМ-5-ын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “*Журам батлах тухай*”-ын 1 дүгээр хавсралт “*Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар*”-ын 4.20 дахь заалтыг хэрэгжүүлэх

3. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас НДШ-ийн зардал руу 112.3 мянган төгрөгийг холбогдох тушаал шийдвэргүйгээр гүйлгэн зарцуулсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

4. **Хөрөнгийн ангилалтай холбоотой асуудал**

4.1. Илрүүлэлт:

Бараа материал оновчтой ангилагдаагүй байна. Тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалыг дэд ангилал үүсгэн бүртгээгүй.

4.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Журам батлах тухай”-ын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай”-ын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг бараа материалаарх хөрөнгийн ангилалд ашиглах, УСНББОУС 12 “Бараа материал”-ын 476 дүгээр параграфын дагуу тодруулга хийх

5. **Авлага, өглөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

5.1. Илрүүлэлт:

Авлага, өглөгийн тооцоог бүрэн нийлж баталгаажуулаагүй, тайланд оны эцэст 72.2 мянган төгрөгийн өглөг, 23.5 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна. Мөн үүссэн өглөг, авлагыг үүссэн тухай бүрд нь бүртгэлд тусгаж хөтлөөгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, 12.2.1,14.4.2, 14.4.3 20.2.5, 20.2.6 дахь заалтууд, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” -ыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мян.төгрөгөөр/							
				Залруулга				Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн	Тоо
1	Орхон аймгийн УЦУОШТ	8	17,564.4	-	-	-	-	1	17,379.9	5	184.5

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ” ХХК-ИЙН

АУДИТОР:

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

ЗАХИРАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

Огноо: 2022.2.25

М.БЯМБАДОРЖ

Огноо: 2/25

Б.БАЙГАЛ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Ц.НАРМАНДАХ

Огноо: